



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/55

Булган сум

**Захирамж хүчингүй болгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 6308003490 нэгж талбар бүхий эзэмшил газрын төлбөрийг жил бүр төлж байсан нь баримтаар нотлогдсон, аймгийн Засаг даргын 2021 оны А/529 дүгээр захирамжаар эзэмшил газрын байршилаа өөрчилсөнөөс хойш Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчөөгүй байх тул аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/289 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан контор, ажилчдын орон сууц зориулалтаар эзэмшиж байсан 6308003490 нэгж талбар бүхий 1607 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг сэргээж, газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6322011187